*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

ИХ-УУЛ, ЯГААНТОЛГОЙ 6 ДУГААР БАГИЙН ЗАСАГ ДАРГА Д.ТҮМЭН-ӨЛЗИЙГИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.** "НЭГ. "Дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангах ажиллах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД" | | | | | | | |
| 1.1 | Тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэх. | Хяналтад авч хэрэгжүүлсэн заалтын тоогоор | 90 | 90 | Тогтоол шийдвэрийн 15 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>-Засгийн газрын 2021 оны 11 сарын 17-ны өдрийн 350 тогтоол "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр, 2007 оны 10 сарын 3-ны өдрийн 257 тогтоол "Угийн бичиг хөтлөх"<br>-Өвөрхангай аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн тогтоол 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн дугаар 37 "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" хөтөлбөр, 2021 оны 11 дүгээр сарын 08 -ны дугаар 66 "Нэг өрх-Нэг ажлын байр" хөтөлбөр , 2021 оны 04 сарын 26-ны өдрийн дугаар 30 "Амар тайван Өвөрхангай" хөтөлбөр 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 16/02 "Нээлттэй Өвөрхангай хөтөлбөр", 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн дугаар 08/04 "Нохойн албан татварын хэмжээг тогтоох тухай" | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Арвайхээр сумын ИТХурлын тогтоол 2021 оны 01 дүгээр сарын 27 -ны өдрийн дугаар 3/01 бүхий “Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай” тогтоолуудын нийт 15 заалтуудыг хяналтад авсан.<br>-Тогтоол шийдвэрийн биелэлт 90 хувьтай хэрэгжүүлэн ажиллалаа. | | |
| 1.2 | “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөрийг сурталчлах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | - | 2 | -“Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөрийн хяналтад авч, төлөвлөгөөг боловсруулж, 3 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилт 90 хувьтай байна.<br>-Сул ажлын байрын зарыг түгээснээр хот болон аймгуудаас шилжин ирсэн хөдөлмөрийн насны 15 иргэнээс 2 иргэн төрийн байгууллагад 12 иргэн хувийн хэвшилд ажиллаж, 1 иргэн 0-1 хүүхдээ харж байна.<br>-Дархан хотоос шилжиж ирсэн нэг өрхөд цагаан хаалганд газар шийдүүлж өгсөн. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| 1.2.1. | Сул ажлын байрны зарыг иргэдэд нээлттэй хүртээмжтэй хэлбэрээр хүргэх. | Иргэдэд хүргэсэн зарын тоогоор | 18 | - | -6 дугаар багийн цахим хаяг болох “Их-Уул Ягаантолгой” нээлттэй пэйж хаяг болон “Их-Уул Ягаантолгойн 6-р баг” хаалттай групп хаяг дээр 93 сул ажлын байрны зарыг түгээн байршуулсан. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| 1.2.2 | Улаанбаатар, Эрдэнэт, Дархан болон бусад хотуудаас шилжин ирж байгаа өрхийн | Хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар | 100 | 100 | -Улаанбаатар, Дархан хотоос 15 иргэн, бусад аймгуудаас 13 иргэн шилжин ирсэнээс 0-15 насны 12 хүүхэд шилжин ирж, Полетехникийн коллежид 1 хүүхэд, ЕБ-ын 2 дугаар сургуульд 7 хүүхэд суралцаж, 2,7,8 дугаар цэцэрлэгт 4 хүүхэд тус тус | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

89

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүүхдүүдийг хамран сурах тойргийн ЕБС, СӨБ-д хамруулах. | | | | хамрагдаж, 100 хувь сургууль, цэцэрлэгт хамрууллаа. | | |
| 1.2.3 | Цахим хүсэлт, өргөдлийг шийдвэрлэх. | E-Mongolia шийдвэрлэлтийн хувиар | 100 | 100 | -E-Mongolia аппликэйшнаар нийт 23 хүсэлтийг хүлээн авч 6 хүсэлтийг зөвшөөрч, хаяг андуурсан 17 хүсэлтийг татгалзсан хариу илгээж, 100 хувь шийдвэрлэж ажилласан.<br>-Цэргийн тоо бүртгэлд 16 иргэн E-Mongolia аппликэйшнаар бүртгүүлсэн. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| 1.3 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 1 | 1 | - "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, сурталчлах, зорилгоор 2024 оны 01 сарын 20-ний өдөр төлөвлөгөөг 3 арга хэмжээний хүрээнд төлөвлөж, 90 хувийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| | | Ногоон байгууламж нэмэгдүүлсэн өрхийн хувиар | 16 | 17 | -"Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд өөрийн өмчлөлийн хашаандаа мод тарих 389 өрхөөс өнөөдрийн байдлаар 49 өрх буюу 12,5 хувь нь 158 ширхэг /голт бор, хайлаас, бургас, чацаргана, монос, агч/ зэрэг моднуудыг тарьсан.<br>-"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх, өрхийн жимсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор багийн Засаг дарга 15 өрхөд нийт 75 ширхэг чацарганы суулгац 375.000 төгрөгөөр авч өгч хашаанд нь тариулсан. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| 1.4 | Багийн хэмжээнд улирал бүр | Шинээр хог хаягдлыг | 15 | 20 | -Багийн нутаг дэвсгэрт 3 удаа бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж, нийт 54 иргэд | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж, хогийг ангилан ялгуулж хэвших, нэгдсэн хог тээврийн хуваарийн дагуу хог ачилтад хяналт тавих. | ангилан ялгах хогийн савтай болсон өрхийн тоо | | | оролцож, 15тн хогийн зөвшөөрөлтэй цэгт хүргүүлэн ажилласан. Улирал бүр нийтийн цэвэрлэгээ хийгдсэнээр багийн иргэд нийтийн эзэмшлийн гудамж талбайд ил задгай хог, угаадас асгах явдал багассан.<br>-Гудамж хариуцсан 15 хэсгийн ахлагч нар хариуцсан гудамжиндаа хяналт тавьж, 56 өрхийн иргэдэд хашааныхаа ойр орчны хогийг цэвэрлэх шаардлага тавьж ажилласан.<br>-Сар бүрийн 5-ны өдрөөс эхлэн хуваарийн дагуу хог ачилт явагддаг тул хяналт тавьж, иргэдэд багийн цахим хаягаар мэдээлэл тогтмол хүргэн ажилладаг.<br>-2024 онд 17 өрх шинээр хог ангилан ялгах савтай болсон байна. | | |
| | | Сургалт, мэдээлэлд хамрагдсан өрхийн тоо | 200 | 250 | -2 удаагийн БИНХуралдаанд оролцсон 260 өрхийн иргэнд амьдарч буй орчиндоо цэвэр, цэмцгэр, хогийг ангилан ялгаж талаар мэдээлэл хүргэж ажилласан.<br>-Онцгой байдлын газрын гал сөнөөгч, аврагч дэд ахлагч Н.Мөнхзаяатай хамтран 126 иргэнд гал түймрээс урьдчилан сэргийлэх, хогийн савыг таглтай болгон мөн ангилан ялгаж, хэвшүүлэх талаар сургалт зохион байгуулсан. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| 1.5 | Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 1 | 35 өрхөд угаар мэдрэгч суурилуулж, агаарын бохирдлыг бууруулахын тулд амьдарч буй орон байрны дуулалга хийх, цахилгаан халаагуур хэрэглэх талаар зөвлөгөө өгч, гарын авлага хүргүүлэн ажилласан. Энэ онд | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

91

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгаа ажлыг дэмжиж, хамтран ажиллах. | | | | 6 өрх шинээр цахилгаан халаагуурыг хэрэглэж байна.<br>-БИНХуралд оролцсон 260 иргэнийг сайжруулсан шахмал түлшийн хэрэглээний зааварчилгааг өгч ажиллалаа. | | |
| | | Сайжруулсан шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлсэн өрхийн хувь | 0.1 | 30 | -Багийн хэмжээнд нийт 712 өрхөөс малчин 89, орон сууцанд 40, хот, аймаг, хөдөө орон нутаг 21, өөр багт 53, утаагүй өрх 27 өрх оршин сууж байна.<br>-Гэр хороолол нийт 482 үндсэн өрх оршин сууж, 93 түр оршин суугч өрх, сайжруулсан шахмал түлш хэрэглэх нийт 575 өрх байна.<br>-Дээрх судалгааны дагуу айл, өрхүүдэд сайжруулсан шахмал түлшийг нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж, 35 өрхөд угаар мэдрэгч суурилуулж, “Батбаянхангай” ХХК-тай борлуулалтын гэрээ байгуулсан боловч түлш хэрэглээнд гараагүй. | 2024.01.01.<br>2024.12.31. | 90 |
| | | Шинээр эко, болон сайжруулсан нойл, муу усны цооногтой болсон өрхийн тоогоор | 4 | 10 | -Цагаан хаалганд шинээр хашаа барьсан 2 өрхөд хугацаатай шаардах хүргүүлж, нойлыг бариулсан.<br>-“Эко нойл” төсөлд 25 өрх хамрагдаж, 21,875.000 төгрөгийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн дансанд төвлөрүүлж, өнөөдрийн байдлаар 14 өрхийн нойлийг 90 хувийн гүйцэтгэлтэй барьж байна.<br>-2024 онд сайжруулсан болон эко нойлтой болсон 16 өрх байна. | 2024.01.01.<br>2024.06.15. | 100 |
| 1.6 | Малчдын “ Аравтын бүлэг”-ийг чадавхжуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 1 | -“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг ажлын хэсгийнхэнтэй хамтарч малчин өрхүүдээр явж, хоршоог сурталчилж, өнөөдрийн | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

92

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажил зохион байгуулах бүлгийн тоог нэмэгдүүлэх. | | | | байдлаар 5 малчин өрх хоршоо байгуулаад үйл ажиллагаа явуулж байна.<br>-Мөн багийнхаа малчдын чат группт байдаг 72 малчинд "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг сурталчилж ажиллаж байна.<br>-3 малчин өрх шинээр ногоон тэжээл худалдан авч тариалсан. | | |
| | | Чадавхжсан Аравтын бүлгийн тоо | 1 | 1 | -Байгалийн давагдашгүй ган зуданд малын хорогдолгүй, хохирол багатай даван туулах, тарга хүчийг нь алдагдуулахгүй онд оруулахад малчдын хамгийн гол анхаарах зүйл бол зун, намрын улиралд хангалттай хадлан бэлтгэх, өвөлжөөний ойролцоо бэлчээрийн талбайг хашиж, малын тэжээл тариалах талаар байнгын зөвлөгөө өгч ажилласнаар энэ онд аравтын 6 бүл 2 га бэлчээрийн талбайг хашаалсан. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| 1.7 | Өвөлжилтийн бэлтгэл хангуулах төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 90 | 100 | Арвайхээр сумын Засаг даргын 2024 оны 08 сарын 19-ний өдрийн А/151 дугаар захирамжийн дагуу өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж, Засаг даргын орлогч даргаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 88.8 хувьтай хийж гүйцэтгэсэн байна. | 2024.08.01.<br>2024.12.31. | 100 |
| 1.8 | "Цахим шилжилтийн эрчимжүүлэх" зорилтот жилийг сурталчилж, төлөвлөгөө гарган ажиллах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | - | 100 | "Цахим шилжилтийн эрчимжүүлэх" зорилтот жилийн төлөвлөгөө 2024 оны 02 сарын 02 өдөр батлаж, 10 арга хэмжээг 90.6 хувьтай хэрэгжүүлэн ажилласан. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

93

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон бичил бизнес эрхлэгчдийг төсөл хөтөлбөрийн сургалтад хамруулах, зуучлах. | Төсөл хөтөлбөрт зуулчилж, сургалтад хамруулсан тоогоор | 4 | 4 | -ХХҮГазрын төсөл хөтөлбөрт 35 иргэнд мэдээлэл өгч ажилласан.<br>-Бейст хөтөлбөрт 2 иргэнийг хамруулж, малжуулах төсөлд 2 малчин өрхийг хамруулсан.<br>-Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт 3 ахмад, ХБиргэн 1 тус тус хамруулсан байна. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| **Зорилт 2.** "Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажиллах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД" | | | | | | | |
| 2.1 | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилж, хэрэгжилтийг хангах ажиллах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 90 | 100 | Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор жил бүрийн гуравдугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагт орон даяар гамшгийн мэдээ зарлан мэдээллийн дуут дохио дуугаргаж, иргэд гамшгаас хамгаалах дадлага, сургалтыг зохион байгуулдаг.<br>-Энэ жилийн дуут дохио 2024.03.28-ны өдрийн 16:00 цагт дуугарч дуут дохионы үеэр иргэдийг заавар, зөвлөмжийн дагуу харьяа багийн аюулгүй талбайд цугларахыг зарлан мэдээлж, гамшгаас хамгаалах дадлага, сургуульд багийн 31 иргэн, 17 авто машин бүртгэж, мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| 2.2 | Өвөрхангай аймгийн анхан шатны Улаанзагалмай хороотой хамтран ажиллах | Шинээр сайн дурын идэвхтэн гишүүдүүд элсүүлсэн тоогоор | 6 | 10 | -Энэ оны байдлаар Улаанзагалмайн хорооны сайн дурын гишүүнээр 9, онцгой гишүүнээр 1 иргэнийг шинээр элсүүлж, татварын төлөлтийг бүрэн хийлгүүлсэн. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

94

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3 | Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулж, хамтран ажиллах | Гэрээний хэрэгжилтийн хувиар | 90 | 90 | “Нарны дөш” өрхийн эрүүл мэндийн төвийн эмч Ц.Цэвэлмаа 2024 оны 01 сарын 11-ны өдөр хамтын ажиллагааны гэрээг байгуулан 8 арга хэмжээг төлөвлөн хамтран ажиллаж, төлөвлөгөөний биелэлт 89 хувьтай гүйцэтгэж, ажиллалаа. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| | | Үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэний хувиар | 75 | 75 | -“Нарны дөш” ӨЭМТ-ийн эмч, сувилагч нартай хамтран 0-2 насны 117 хүүхдүүдийг вакцинжуулалтад 98 хувьтай бүрэн хамруулсан.<br>-Нөхөн үржихүйн насны 696 эмэгтэйг хамруулахаас 564 буюу 81 хувтай, 18-55 насны 1277 иргэдийн цусны даралт хамруулахаас 1085 буюу 85 хувь , 35-55 насны 656 иргэдийг чихрийн шинжингийн эрт илрүүлэлтэд хамруулахаас 532 буюу 81 хувьтай хамруулсан байна.<br>-24 эхийг жирэмсний хяналтад авч эх хүүхдийн эндэгдэл гаргаагүй байна.<br>-Цэргийн насны 62 залууг эрүүлжүүлэх үзлэгт 85 хувьтай ажилласан.<br>- 88 иргэнийг гэрийн сувилахуйн үйлчилгээнд хамруулж, өдрийн эмчилгээнд 230 иргэн, сэргээн засах эмчилгээнд 125 иргэн, оношилгоо шинжилгээнд 170 ахмад тус тус хамруулсан.<br>-Багийн 79 ахмадыг витаминжуулсан.<br>-Цахим хуудсаар 12 зөвлөмж, 9 зурагт мэдээлэл, 5 видео сэрэмжлүүлгийг байршуулан мэдээлэл хүргэсэн. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

95

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4 | Мал эмнэлгийн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, хамтран ажиллах | Гэрээний хэрэгжилтийн хувь | 90 | 100 | -“Баян сүргийн буян” мал эмнэлгийн малын эмч С.Эрдэнэбилэгтэй гэрээ байгуулж, малчин болон мал бүхий 132 өрх, 1 аж ахуйн нэгжийн судалгааг гарган өгч, хуваарилсан тарилга туулгыг цаг хугацаанд нь 100%-тай гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэсэн.<br>-Гэрээнд заасны дагуу малын эрүүлжүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хугацаатай тарилга, туулга, вакцинд бүрэн хамруулах тал дээр анхааран ажилласан. Үүнд: 2023 онд 26282 толгой тоологдсон. Үүнээс хонь, ямааны ДХХ 100 хувь, шөвгийн вакцин 100 хувь, бруцелёз бог малын төлд 100 хувь, үхрийн цусан халдварт 100 хувь, галзуугийн вакцин 400 малд шүлхийн хаврын тарилга 100 хувь, хонь, хурга цэцгийн вакцин 100 хувь, мялзангийн вакцин 100 хувь, сахуугийн вакцин унаганд 100 хувьтай тус тус вакцинжуулалтад хамруулан ажилласан. | 2024.01.01. 2024.12.31. | 100 |
| 2.5 | Хагас жил болон жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулж, хуулийн хугацаанд программд оруулах. | Мэдээг мал тооллогын программд алдаагүй үнэн зөв оруулсан хувиар | 100 | 100 | Хагас жилийн түүвэр тооллогоор 19 өрх сонгогдон ирж, 3872 толгой мал тоологдож, программд бүрэн шивж ажилласан. | 2024.01.01. 2024.06.15. | 100 |
| 2.6 | “Багийн хамтарсан баг”-ийн үйл | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 85 | 85 | -2024 оны 01сарын 05 өдөр “Хамтарсан баг”-ийн төлөвлөгөө гаргаж, 5 арга хэмжээний 14 | 2024.01.01. 2024.12.31. | 100 |

96

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөг батлах, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах | | | | заалтыг төлөвлөн хэрэгжилт 89 хувьтай байна.<br>-Хагас жилийн байдлаар хүүхдийн тусламжийн 108 утсаар 2 дуудлага бүртгэгдэж, шинээр нээж, үргэлжилж байгаа 8 кейс, нийт 10 кейсээс 4 кейс хааж ажилласан. 10 өрхийн нийт 45 иргэнд хамтарсан багаар нөхцөл байдлын үнэлгээ хийн, хамтарсан багаар 3 удаа хуралдаж, кейс нээн ажиллаж байна.<br>-Мөн хамтарсан багийн гишүүд болон 15 хэсгийн ахлагчтай нууцын баталгаа хийж, хамтарч ажиллах гэрээ байгуулан ажилласан. | | |
| 2.7 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 3 | 5 | -Багт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 01 сарын 11-нд батлаж, 5 арга хэмжээг төлөвлөн 91 хувийн биелэлтийг хангаж ажилласан.<br>-Гэр айлчлалаар бага насны хүүхэдтэй айлуудаар давхардсан тоогоор 45 өрхүүдэд хүүхдийн аюулгүй орчинг бүрдүүлэх шаардлага тавин ажилласан.<br>-Багийн иргэдийн нийтийн 2 удаагийн хурлаар 260 иргэнд хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хууль эрх зүйн мэдээллээр гарын авлага бэлтгэн эцэг, эхчүүдэд хүргэсэн.<br>-Арвайхээр сумын хамтарсан баг "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэргийлэх", Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх", "Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хамтарсан багаар хууль, эрх зүйн мэдээллээр гарын авлага бэлтгэн 13 багийн нийт нутаг дэвсгэрээр 3 өдөр Явуулын үйлчилгээг хүргэж 356 иргэн үйлчилгээ үзүүлж ажилласан.<br>-2,7 дугаар багийн ажлын албатай хамтран ЕБ-ын 1 дүгээр сургуулийн дотуур байранд байдаг 101 сурагчид сургалт зохион байгуулж, санал асуулгын авч ажилласан.<br>-ЕБ-ын 2 дугаар сургуулийн 7,8 дугаар ангийн 150 гаруй сурагчдад "Цахим орчны зохистой хэрэглээ", "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сургалт, ярилцлагыг зохион байгуулсан.<br>-3*3сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж, оролцсон 30 хүүхдүүдэд сургалт зохион байгуулж, санал асуулгын хуудас бөглүүлсэн.<br>- Дээрх 13 мэдэгдэл, 1 шаардлагаас 5 үндсэн иргэн, 9 иргэн түр оршин суугч байгаас үйлдсэн хэргийг судалж үзэхэд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, өмчлөх эрхийн эсрэг, хүний амьд явах эрхийн эсрэг, гэр бүлийн хүчирхийлэл, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, эх нярай хүүхдээ алах гэх хэргүүд үйлдэгдсэн тул дээрх хамаарал бүхий хуулийн дагуу гарын авлага | | |

98

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бэлтгэн багийн цахим группээр түгээж 1120 иргэн хандалттай авч, 942 иргэн арга хэмжээг зохион байгуулсан байсан нь урьд оноос гэмт хэргийн гаралт 0,9 хувиар буурсан байна. | | |
| 2.8 | Хөдөө аж ахуйн ХАА-1, ХАА-2, ХАА-3, ХАА-5, ХАА-6, ХАА-7, ХАА-8, ХАА-9, ХАА-10 мэдээнүүдийг хугацаанд нь үнэн зөв гаргаж, нэгтгүүлэх. | Мэдээний тоо | 47 | 47 | Долоо хоног бүрийн 2 дахь өдөр малчдаас төл бойжилт, хорогдлын мэдээг авч, сумын МААХариуцсан мэргэжилтэнд хүргүүлэн, medee.app.nso.mn нэгдсэн мэдээллийн апп-д шивэлтийг хийж ажилласан.<br>-2024 оны байдлаар 6241 төллөсөн хээлтэгч төллөж, 69 төл хорогдсон байна.<br>-Том малын зүй бусын хорогдол нийт 310 толгой мал хорогдсон байна.<br>-Төл бойжилт, хорогдол, хаваржилтын мэдээг цаг хугацаанд нь гаргаж, багийн хаалттай фэйсбүүк болон багийн мэдээллийн самбарт байршуулан ажилласан. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| 2.9 | Багийн зохион байгуулагч, нийгмийн ажилтныг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах. | Өгсөн үүрэг даалгавар, арга зүйн зөвлөмжийн биелэлтийн хувиар | 95 | 95 | -Багийн зохион байгуулагч, нийгмийн ажилтныг удирдлага, арга зүйгээр хангаж, арга зүйн зөвлөгөө өгч, тэдний санал санаачилгыг дэмжин ажиллаж байна.<br>-Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх, QR кодыг уншуулж, цахим хэрэглээнд нэвтрүүлэх, цахим мэдээлэл бэлтгэх, иргэдийн мэдээлэл авах боломжийг бий болгох, зэрэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор багийн Зохион байгуулагч | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

99

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | С.Хулиунаад үүрэг даалгавар өгч ажиллалаа.<br>Үүний хүрээнд: БЗДААлбаас бэлтгэсэн 9 гарын авлага, эмхэтгэл QR -ыг бэлтгэн 489 иргэнд хүргэж, багийн цахим хуудсаар дамжуулж, 1120 иргэнд хандалттай авч санаачилга гарган хамтран ажиллалаа.<br>-Иргэдийг гэр бүлийн хүчирхийллээс ангид байлгах, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, гэрээр айлчилж, судалгааг үнэн зөв бодитой гаргах, нийгмийн халамжийн үйлчилгээ шаардлагатай иргэдийг шат дараатай хамруулах, иргэдийг ажлын байранд зуучлах, төсөл хөтөлбөрт хамруулах, кейс менежементийг сайжруулах, зураглал гаргаж ажиллах, зорилтот бүлгийн иргэдийг сургалт, арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг багийн нийгмийн ажилтан М.Оюунтөгс үүрэг болгосон.<br>Өгсөн үүрэг даалгаврын хүрээнд давхардсан тоогоор 45 өрхөөр айлчилж, 10 кейс нээж, 4 кейсийг хааж, 5 төрлийн сургалт 406 иргэнд зохион байгуулж, зорилтот бүлгийн 2 өрхийг орон гэртэй болгож, аймаг, сумын Засаг даргын нөөцөөс 17 иргэнд 8,500,000 төгрөгийн дэмжлэг, 6 иргэний төсөл хөтөлбөрт хамруулахад хамтран санаачилгатай ажиллалаа. | | |

100

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.10 | БИНХ-ыг зохион байгуулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, биелэлтийг тайлагнах | Зохион байгуулсан хурлын тоо | 3 | 3 | БИНХурлыг хагас жилийн байдлаар 2 удаа зохион байгуулсан. | 2024.01.01. 2024.12.31. | 100 |
| | | Гарсан шийдвэрийн хэрэгжилтийн хувиар | 90 | 100 | -Алдарт эхийн I, II зэргийн одонгоор шагнагдах 7 эхийн материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлэн хугацаанд нь уламжилж, одон олгууллаа.<br>- Багийн Иргэдийн нийтийн хуралд нийт 260 иргэн хуралд оролцож, 32 санал асуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, 24 саналыг дээд байгууллагад уламжилж ажилласан.<br>-2 дугаар улирлын БИНХурлын хуралдаанаар 2025 онд ОНХСХөрөнгөөр хийх ажлын саналыг эрэмбэлүүлж, холбогдох материалуудыг ХЗАлбанд хүргүүлсэн. | 2024.01.01. 2024.12.31. | 100 |
| **ГУРАВ. "Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД"** | | | | | | | |
| 3.1 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг тухай бүр үнэн зөв мэдээллээр хангах. | Үүрэг даалгаврын хэрэгжилт хувь | 100 | 100 | -Арвайхээр сумын Засаг даргын Тамгын Газрын даргын өгсөн үүрэг даалгаврын хүрээнд багийн Зохион байгуулагч, Нийгмийн ажилтны ажлын эрчимжүүлэх, илүү санаачилгатай ажиллах талаар үүрэг даалгаврыг өгч биелэлтийн хөтлөн ажиллаж байна. | 2024.01.01. 2024.12.31. | 100 |
| 3.2 | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь | Шийдвэрлэлтийн хувь | 90 | 100 | -Багийн хэмжээнд нийтдээ 63 иргэний өргөдөл ирсэнийг бүртгэлийн дэвтэрт бүртгэж, дээд шатны байгууллагад уламжилж, хуулийн цаг хугацаанд нь шийдвэрлүүлсэн. | 2024.01.01. 2024.12.31. | 100 |

101

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлэж, хариуг өгөх | | | | -Тусламж, дэмжлэг хүссэн 17 өргөдлийн хүлээн авч аймаг, сумын Засаг даргад уламжилж, /8,500,000 төгрөг/-ийн дэмжлэг үзүүлсэн байна.<br>-Журмын дагуу түлшний хөнгөлөлтөд хамрагдах 36 өргөдлийг дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлсэн.<br>-Алдарт эхийн одонгийн 7 материалыг журмын дагуу бүрдүүлж, сумын ИТХ-д хүргүүлсэн.<br>-Төрийн дээд шагналд 3 иргэнийг уламжилсан. | | |
| **ДӨРӨВ. “Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 4.1 | Жилийн ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, батлуулан дүгнүүлэх. | Хэрэгжилтийн хувь | 90 | 100 | -Жилийн ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан 33 зорилт, 41 шалгуур үзүүлэлтийг хангаң боловсруулж, ЗДТГазрын даргаар батлуулан, хэрэгжилтийг хангаң ажилласан. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| 4.2 | Хугацаатай албан бичиг, тайлан мэдээ, судалгааг бүрэн үнэн зөв гаргаж хугацаанд нь холбогдох | Хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд хүргүүлсэн, хувиар | 100 | 100 | -Өвөрхангай аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мөрдөгчийн 13 мэдэгдэл, Цагдаагийн газрын шаардлага 1 хүлээн авч, 5 иргэдтэй ганцаарчлан уулзаж, 3 гэрээр нь айлчилж, 8 иргэнтэй утсаар зөвлөгөө, мэдээлэл өгч, “Одоо больё” сургалтад | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

102

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | газруудад хүргүүлэх. | | | | хамруулж, илтгэх хуудсыг цаг хугацаанд нь тухай байгууллагад хүргүүлэн ажилласан.<br>-Дээрх 13 мэдэгдэл, 1 шаардлагаас 5 үндсэн иргэн, 9 иргэн түр оршин суугч байгаас үйлдсэн хэргийг судалж үзэхэд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, өмчлөх эрхийн эсрэг, хүний амьд явах эрхийн эсрэг, гэр бүлийн хүчирхийлэл, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, эх нярай хүүхдээ алах гэх хэргүүд үйлдэгдсэн тул дээрх хамаарал бүхий хуулийн дагуу гарын авлага бэлтгэн багийн цахим группээр түгээж 1120 иргэн хандалттай байна.<br>-ШШГГазраас ирүүлсэн 6 албан бичгийн хариуг хүргүүлсэн. | | |
| | | Хугацаатай мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлсэн, хувиар | 100 | 100 | -Хугацаатай мэдээ, тайланг хугацаанд нь үнэн зөв гаргаж, хүргүүлэн ажилласан.<br>-Хугацаа хоцруулсан мэдээ, тайлан байхгүй болно. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| 4.3 | Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журам, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, цаг | Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй ажилласан байна. | 100 | 100 | -Албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүйн талаар амаар болон бичгээр гомдол гараагүй.<br>-Байгууллагаас санаачилж зохион байгуулсан аливаа ажилд санаачилгатай, идэвхтэй оролцсон.<br>-Засгийн газрын 2024 оны 10 сарын 02 өдрийн 109 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

103

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ашиглалт, ажлын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэх. | | | | албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" байгууллагын "Дотоод журам"ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлсэн.<br>-Төрийн албан хаагчийн хувийн хэрэгт ёс зүйн зөрчлийн тэмдэглэл хийгдээгүй. | | |
| | | Ажлын цагийн хоцрогдол, ашиглалтын хувиар | 100 | 100 | -Цаг бүртгэлийн "AbleMoments" апп-ыг ашиглаж байна. Ажлын цагийн хоцрогдолгүй ажиллаж байна. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| 4.4 | Хяналт, шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | - | 50 | Хяналт, шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 2024.01.01.<br>2024.12.31. | 90 |
| 4.5 | Байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцох | Хамрагдсан арга хэмжээний тоогоор | 3 | - | -Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан цахим сургалтад тухай бүр хамрагдсан.<br>-Байгууллагын цагаан сарын золголт арга хэмжээнд оролцсон.<br>-Албан хаагчдын дунд зохион байгуулсан "Гар бөмбөг"-ийн тэмцээнд орсон.<br>-Байгууллагын ёс зүйн дэд хорооны 2024 онд хийгдэх ажлыг гишүүдийн хамт төлөвлөж, хуваарийн дагуу гүйцэтгэсэн. | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |
| 4.6 | Байгууллага, баг туршлага болохуйц шинэлэг | Арга хэмжээний тоогоор | 2 | 2 | -Багийн ажлын албанаас зохион байгуулсан 5 сургалт, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх болон угийн бичиг хөтлөх нийт | 2024.01.01.<br>2024.12.31. | 100 |

104

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулах | | | | 5 гарын авлага, “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жилийн сурталчилах 4 гарын авлага, багийн Засаг даргын тайлан зэргийг QR код уншуулж, авч цаасны хэрэглээг багасгах, иргэдийг цахим мэдээллээр хангах зорилго тавин ажиллаж, 489 иргэнд дээрх гарын авлага болон QR кодыг хүргүүлсэн нь үр дүнтэй ажил болсон.<br>-“Миний гэр бүлийн аз жаргал” номыг бэлтгэн гаргаж, “QR” кодыг гар утасныхаа камераар уншуулж, багт иргүүлэх санал, хүсэлтийг гомдол, талархлыг хүлээн авч ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 32 санал 15 талархлыг хүлээн авсан. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Хүрсэн түвшин (биелэлт) | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Арвайхээр сумын шуурхай штабад жижүүрийн үүрэг гүйцэтгэх | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн байна | -Онцгой комиссын шуурхай штабт 2 удаа жижүүрээр үүрэг гүйцэтгэж, сумдын уул уурхайд ашигладаг хүнд машин махенизмын судалгааг гаргаж, 19 сумаас цаг үеийн мэдээлэл, өвс тэжээлийн нөөцийн мэдээг авч нэгтгэн ажилласан. | 100 |
| 2 | Өсвөрийн хүүхдүүдийн бөхийн УАШ тэмцээний зохион байгуулалтад оролцох | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн байна. | -УАШ тэмцээнд “Говь-Сүмбэр” аймгаас оролцсон баг тамирчдыг хариуцан ажилласан. | 100 |
| 3 | Төрийн албан хаагчдын бүсийн уулзалт | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн байна. | -Бүсийн уулзалтад оролцсон “Булган” аймгийн алба хаагчдыг хариуцан ажилласан. | 100 |

105

**ХОЁР. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Отгонтэнгэр Их Дээд сургуулийг “Эрх зүйч” ангийн 2 дугаар курсээ амжилттай төгсөх. | Судалсан кредит цаг /40 кредит/ | 40 | 40 | 40 кредит хичээлийг үзэж, судалж байна. | 2024.01.01. 2024.12.31. | 100 |
| 2 | Монгол бичгийн мэдлэгээ ахиулах | Албан бичиг боловсруулж сурах | Дунд | Ахьсан | -Байгууллагаас зохион байгуулсан “Монгол хэл бичиг”-ийн сургалтад хамрагдсан.<br>-Хүмүүн бичиг сониныг захиалж, мэдлэгээ ахиулж байна. | 2024.01.01. 2024.12.31. | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ИХ-УУЛ, ЯГААНТОЛГОЙ 6 ДУГААР БАГИЙН
ЗАСАГ ДАРГА ........................ /Д.ТҮМЭН-ӨЛЗИЙ/

2024.11.25.

106